



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/163

Чингис хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 4.3.7 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын хэмжээнд 2025 оны зуны улиралд үер усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ын хүрээнд боловсруулсан аргачлалын дагуу хийж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

|                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|-----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: | Г.Лхагвабаатар-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| Нарийн бичгийн дарга: | Д.Буянбат-Байгаль орчны хяналтын улсын байцаагч                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| Гишүүд:               | Ж.Алтантөгс -Газар тариалан, ХАА асуудал хариуцсан мэргэжилтэн<br>О.Түмэндолгор-Хэрлэн сумын байгаль хамгаалагч<br>Ж.Эрхэмбаяр-Хэрлэн сумын газрын даамал<br>Э.Золбаяр-Барилга дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн<br>Г.Цэрэнтогтох-Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн<br>Б.Эрдэнэбилэг-Хэрлэн багийн Засаг дарга<br>М.Хүрэлчулуун-Булаг багийн Засаг дарга<br>Б.Мөнхбаяр-Баянмөнх багийн Засаг дарга<br>Ё.Баяртулга-Сариг багийн Засаг дарга<br>А.Мөнх-Эрдэнэ-Өндөрхаан багийн Засаг дарга<br>Д.Мөнхтуяа-Цогт-Өндөр багийн Засаг дарга<br>Д.Алтаннараа-Номгон багийн Засаг дарга<br>Ө.Зоригт- Ишгэнтолгой багийн Засаг дарга |
| Зөвшилцсөнөөр:        | Г.Золжавхлан Гал түймэр унтраах 32 дугаар ангийн захирагч<br>С.Баясгалан-УЦУОШГ-н Ус судлалын судалгааны инженер                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |

2.Хэрлэн сумын үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг холбогдох байгууллагын төлөөлөлтэй хамтран батлагдсан аргачлалын дагуу боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

В:\Албан тоот 2015\Zahiramj\Захирамж 2015.doc